



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 1/02

Улаанбаатар хот

**2022 оны ээлжийн амралтын хуваарь
батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, 99.5 дугаар зүйл, “Хот, төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалт, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус Институтийн ажилтнуудын 2022 оны ээлжийн амралтын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Ажилтнуудын ээлжийн амралтыг хуваарийн дагуу олгох, зайлшгүй ажлын шаардлагаар хуваарьт өөрчлөлт орвол тухайн ажилтны хариуцсан ажил үүргийг зохицуулан 2022 ондоо багтаан амруулахыг хэлтсийн дарга нарт (Л.Эрдэнэбат, Л.Ганбат, Р. Амартүвшин, Ш.Энхжаргал, Г.Уранбайгал, В.Мөнхжаргал, Б.Гүнжидмаа, Э.Уянга) даалгасугай.

3. Хариуцсан хэлтсүүдийн ажил, төлөвлөгөө, цаг үеийн нөхцөл байдалд тохируулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, ээлжийн амралтын хуваарь, зохицуулалтад хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага санхүүгийн хэлтсийн дарга (Л. Эрдэнэбат), Судалгаа хариуцсан орлогч дарга (С.Очир-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

4. Ажилтнуудын ээлжийн амралтыг “Ээлжийн амралт олгох хуудас”-аар олгож, хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (Ч.Рэнцэнхорлоо)-д даалгаж, “Ээлжийн амралт олгох хуудас”-ыг үндэслэн ажилтнуудын ээлжийн амралтын мөнгийг тооцож олгохыг Нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л. Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.РЭГЗМАА

3150600587